



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай


Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай албан даалгаврын 20.3-т "Хот байгуулалтын чиглэлээр Сингапур Улсад туршлага судлах, Монгол Улсад нутагшуулах боломжтой шийдлийг нэвтрүүлэх" ажлаар Гүйцэтгэх захирал Б.Эрдэнэбулганыг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл 5 хоногийн хугацаатай албан томилолтоор ажиллуулсугай.
2. Томилолтын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, томилолтын зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Томилолтын зардлыг холбогдох журмын дагуу тооцож олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхтуяа/-д зөвшөөрсүгэй.
4. Томилолтоор ажилласан тухай тайланг томилолтоор ажиллаж дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал Б.Эрдэнэбулганд үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дарга /Л.Амгалан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ



ТОМИЛОЛТЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай албан даалгаврын 20.3-т “Хот байгуулалтын чиглэлээр Сингапур Улсад туршлага судлах, Монгол Улсад нутагшуулах боломжтой шийдлийг нэвтрүүлэх”

Хоёр. Хугацаа: 2024.12.02-2024.12.06

Гурав. Хийгдэх ажил:

- БНСиУ-ын дагуул хот, шинэ суурьшлын бүс хөгжүүлэх, орон сууцны төлөвлөлтийн ирээдүйн чиг хандлага, дахин төлөвлөлт, шинэ дэвшилтэд технологийг Монгол Улсад нэвтрүүлэх, энэ чиглэлийн хууль, эрх зүйн орчинг судалж, техникийн хамтын ажиллагаа эхлүүлэх, хөрөнгө оруулалт татах чиглэлээр яриа хэлэлцээ хийх;
- Үндэсний орон сууцны корпораци байгуулахтай холбогдуулан тус улсын орон сууцны зөвлөлийн үйл ажиллагааг судлах, хамтран ажиллах;
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй төрийн байгууллагуудтай хоёр талт хамтын ажиллагааны уулзалтуудыг хийх;

Дөрөв. Хүрэх үр дүн:

Монгол Улсын Засгийн газраас баримталж буй шинэ хотуудын ногоон, тогтвортой, орлогод нийцсэн орон сууцны хүртээмжийг сайжруулах, иргэдийг орлогод нийцсэн, тогтвортой орон сууцаар хангах зорилтуудын хүрээнд:

1. Хамтын ажиллагааг өргөжүүлж, төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх;
2. Хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурах;
3. Шинэ хотуудын төлөвлөлтийг иргэдэд ээлтэй, хүртээмжтэй болгох замаар ухаалаг, ногоон барилгын норм, дүрэм, стандартыг нэвтрүүлэх;


Тав. Бүрэлдэхүүн:

- Улсын их хурлын гишүүд
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
- Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
- 20 минутын хот төслийн үндэсний хороо
- Нийслэл хот
- Барилга хөгжлийн төв
- ТОСК ТӨХХК

Зургаа. Тайлан:

Томиллолтоор ажилласан тухай тайланг ажлын 5 хоногт багтаан танилцуулах.

"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн ТУЗ-ийн
2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 2 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт



Томилолтын зардлын тооцоо:

№	Зардлын төрөл	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Хэмжих нэгж	Ажиллах хоног	Дүн	Тайлбар
1	Улаанбаатар-Сингапур-Улаанбаатар /нислэгийн тийз/	1		төгрөг		3,812,800.00	
2	Зочид буудал / 1 хоног-150\$/	1	512,260.50	төгрөг	5	2,563,065.00	Сангийн сайдын 2011 оны 188-р тушаалаар томилолтын зардлыг тооцов.
3	Зам хоног / 1 хоног- 50\$/	1	170,753.50	төгрөг	6	1,025,226.00	
4	Хот доторх унааны зардал /10\$/	1	34,150.70	төгрөг	6	205,045.20	
Нийт дүн						7,606,136.20	

Жич: Монгол банкны 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн долларын ханш- 3,415.07 төгрөг

---o0o---